



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

БАЯЛАГ БА БОЛОМЖИЙГ УДИРДАХ НЬ:

Уул уурхайн орлого, баялгийн сан

Илтгэгч: СЯ-ны Санхүүгийн бодлогын газрын дарга Ц.Зоригтбат

2018-09-27

АГУУЛГА

1. Уул уурхайн орлого

2. Баялгийн сан, олон улсын туршлага

3. Өмнө байгуулсан сангууд

4. Төсвийн тогтворжуулалтын сан

5. Ирээдүйн өв сан

2018 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО 7,862.9 ТЭРБУМ ТӨГРӨГ

92%

2%6%

■ Тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламж – 7,231.4 тэрбум төгрөг

Эх үүсвэр: Татварын болон татварын бус орлого


■ Тогтворжуулалтын сангийн орлого – 122.7 тэрбум төгрөг

Эх үүсвэр: Ашигт малмалын нөөц ашигласны төлбөр /Тэнцвэржүүлсэн үнээс дээш гарсан хэсэгт ногдох орлого/

■ Ирээдүйн өв сангийн орлого – 508.7 тэрбум төгрөг


Эх үүсвэр: Ашигт малмалын нөөц ашигласны төлбөр /Тэнцвэржүүлсэн АМНАТ-ын орлогын 65%/
Ногдол ашгийн орлого

НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГОД УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ



■ Уул уурхайн орлого □ Уул уурхайн бус орлого

Төсөвт орох эрдэс баялгийн орлогын төсөөлөл



БАЯЛАГ, БОЛОМЖИЙГ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ? БАЯЛГИЙН САН?



*Sovereign Investment Lab-ын тодорхойлолт

Олон улсын сангууд

- Олон улсын баялгийн сангууд: 49 орны 78 сан
- Нийт хөрөнгө: 7.4 их наяд ам.доллар

Нийтлэг эх үүсвэр:

- Ашигт малтмалын орлого
- Төсвийн илүүдэл
- Гадаад валютын илүүдэл
- Бусад эх үүсвэр

Хөрөнгийн удирдлага:

- Хөрөнгө оруулалтын корпораци
- Төв банк

Топ 5 сангууд	Байгуулсан он	Хэмжээ (\$ тэрбум)
1 Норвеги: GPFG	1990	922,11
2 Арабын Нэгдсэн Эмирт Улс: ADIA	1976	828
3 Хятад: CIC	2007	813.8
4 Кувейт	1953	592
5 Саудын араб: SAMA	1952	514


Эх үүсвэр: Баялгийн сангийн хүрээлэн

ЗОРИЛГО


Тогтворжилт: ЭЗ-ийн халалт, голланд өвчнөөс сэргийлэх, төсвийн тогтвортой байдлыг бий болгох;

Хуримтлал: Байгалийн баялгийн орлогыг одоо болон ирээдүй үед тэгш хүртээх зорилгоор хуримтлуулах

Болзошгүй нөөц бүрдүүлэх: Хүн ам зүйн хүчин зүйлээс үүсэх тэтгэврийн тогтолцооны зарлагыг санхүүжүүлэх г.м



ӨМНӨ БАЙГУУЛСАН САНГУУД



ӨМНӨ БАЙГУУЛСАН САНГУУД - МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САН

❑ **2007 онд хуулиар байгуулагдаж 2007-2009 онуудад ажилласан**

❑ **Эх үүсвэр:**

- зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого;
- улсын төсвийн ашиг
- Хуульд заасан бусад

❑ **Зарцуулалт:**

- давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн төсвийн орлогын дутагдлыг нөхөх,
- хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх,
- хүүхэд, гэр бүлийг дэмжих (0-18 хүртэлх насны хүүхдэд сар тутам олгох 3,000 төгрөгийн тэтгэмж, шинээр гэрлэгсдэд олгох 500,000 төгрөгийн мөнгөн тусламж, шинээр төрсөн хүүхдэд олгох 100,000 төгрөгийн мөнгөн тусламж, “Үдийн цай” хөтөлбөр

❑ МУХС-д нийт 1 их наяд 286.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд 1 их наяд 260.2 тэрбум төгрөгийн зарцуулалт хийсэн байдаг. Өөрөөр хэлбэл санд санхүүгийн хуримтлал үүсгээгүй, бүх хөрөнгийг зарцуулсан байна.

❑ Ашигт малтмалын орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, мөн ашигт малтмалын орд газраас орсон орлогоос иргэдэд тэгш хүртээх зорилгоор УИХ-аас 2009 онд Хүний хөгжил сангийн тухай хуулийг баталсан.


❑ **Эх үүсвэр:**

- ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувь (2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар 65 хувь болсон)
- стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын төрд ногдох ногдол ашиг
- Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа төлбөр, зээлийн тодорхой хэсэг

❑ **Зарцуулалт:**


- Хүний хөгжил сангаас 2008-2012 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэн бүрт 1.5 сая төгрөг олгох арга хэмжээ (иргэн бүрт 500 мянган төгрөг бэлнээр 2010-2013 онуудад хуваан олгох)
- Төр хариуцах ЭМД-ийн шимтгэл
- Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 0-18 насны хүүхэд бүрд сар бүр 20 мянган төгрөг олгох

ХҮНИЙ ХӨГЖИЛ САН



- ❑ Хүний хөгжил сангаас 2010-2016 оны хооронд 3 их наяд 129.4 тэрбум төгрөгийн зарлага гаргасан.
- ❑ Тус санд 2 их наяд 350 тэрбум төгрөгийн орлого АМНАТ болон ногдол ашиг хэлбэрээр төвлөрч, зарлагын дийлэнх хэсгийг стратегийн орд ашиглахтай холбоотой Оюутолгой ХХК, Эрдэнэс МГЛ ХХК аас авсан урьдчилгаа төлбөр, Засгийн газрын бондоор санхүүжүүлсэн байна.


ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН, ИРЭЭДҮЙН ӨВ САН 2018 ОН



- ❑ 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдсанаар Төсвийн тогтворжуулалтын сан (ТТС)-г байгуулсан.
- ❑ эдийн засгийн мөчлөг болон эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, тогтворжуулах зорилготой
- ❑ Төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар үнэ тогтвортой буюу өсөлттэй үед хуримтлуулдаг.

ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

ТТС-нд шилжүүлсэн эрдэс баялгийн орлого, сангийн зарлага, хуримтлал,
/тэрбум төгрөг/



ИРЭЭДҮЙН ӨВ САН

- ❑ Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдаж 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн;
- ❑ ИӨС нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байхаар байгуулагдсан бөгөөд Хүний хөгжил сангийн тухай хууль 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсон;
- ❑ Ирээдүйн өв сан нь эрдэс баялгаас бий болсон их хэмжээний орлогыг ирээдүй хойч үеийнхэндээ үлдээх, урт хугацаанд баялгийг хуримтлуулах, арвижуулах баялгийн сан юм.

ИРЭЭДҮЙ ӨВ САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ДҮРЭМ

Орлого: 2017 оноос эхлэн

- ❑ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь;
- ❑ Стратегийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төрийн мэдлийн хувьцааны ногдол ашиг;
- ❑ УУ-н орлогын 2017 оны гүйцэтгэлээс давсан хэсгийн 20 хувь;
- ❑ Хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос улсын төсөвт хуваарилаад үлдэх хэсэг;
- ❑ Татварын хууль, тогтоомжид өөрчлөлт орсноор уул, уурхайгаас нэмэгдэж орох орлогын 50 хувь


Зарцуулалт:

- ❑ 2030 оноос Хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувь;
- ❑ Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой Корпорацийн зардал, хуульд заасан хөндлөнгийн аудитын зардлыг Сангийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.



Яагаад хуримтлуулах хэрэгтэй гэж?

- Ирээдүй хойч үеийн өмнө хүлээх үүрэг:** Үе хооронд баялгийг тэгш, хүртээмжтэй хуваарилах
- Өнөөгийн баялгийг мөнхөд өвлүүлнэ:** Шавхагдах байгалийн нөөцийг шавхагдашгүй санхүүгийн хуримтлал болгон хөрвүүлэх
- Ирээдүйн санхүүгийн боломж бүрдүүлнэ:** Байгалийн баялаг шавхагдах үед төсвийн орлогыг сангийн өгөөжөөр нөхөх

Орлогын хуваагдал:



Хуримтлал, өгөөж, их наяд төгрөг:




Тайлбар:

- Оюутолгойн далд уурхайн ашиглалтад орсон нөхцөлд 2020 оноос уул, уурхайн орлогыг огцом өсгөнө;
- Ирээдүйн өв санг байгуулснаар 2020-2030 оны орлогын өсөлт зарцуулагдахаас сэргийлж, 2030 оноос орлого буурахад төсөвт өгөөжөөсөө шилжүүлж, төсвийн зардал хумигдах, нийгмийн үйлчилгээ буурахаас сэргийлнэ;

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГААС ИРЭЭДҮЙН ӨВ САН РУУ ШИЛЖИХ СТРАТЕГИ

- ❑ Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль:
- ❑ Хүний хөгжил сангийн өр болох 1 их наяд 71.9 тэрбум төгрөгийг барагдуулах
- ❑ Улсын төсөвт 2017-2019 онуудад нийт 210 тэрбум төгрөгийг шилжүүлнэ.




ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

- ❑ Санд төвлөрүүлэх хөрөнгийг Жил бүрийн улсын төсөвт тусгаж батална гэж заасан
- ❑ 2017 онд 357.7 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу 160 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлж, 196.9 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт шилжүүлж, уг өрийн үлдэгдэл 875 тэрбум төгрөг болсон.
- ❑ 2018 онд санд 508.7 тэрбум төгрөг хуваарилагдахаар байгаа ба улсын төсөвт 100 тэрбум төгрөг шилжүүлж, дээрх өрийн хэмжээ 408.7 тэрбум төгрөгөөр буурна.
- ❑ Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг байгуулах, хөрөнгө оруулалтын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэх бэлтгэлийг хангахад чиглэсэн ажлууд хийгдэж байна.



ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СОНГОЛТ





МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА